



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 07 өдөр

Дугаар АМЗ

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1 б, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал" төсөлтэй хамтран санхүүжүүлж буй "Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон Баян-Адарга, Баян-Овоо, Норовлин сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө"-г боловсруулах ажлын хүрээнд газрын доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах асуудлыг тусгах, шаардлагатай мэдээллээр тухай бүрт хангах, санал, дүгнэлт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, боловсруулсан ерөнхий төлөвлөгөөний төслийг батлуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Салбар дундын мэргэжлийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Чогсомжав	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Д.Баярхүү	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга
Гишүүд:	Ж.Гантулга	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Э.Мөнх-Эрдэнэ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Б.Дархантөр	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
	Г.Сэдэдмаа	Статистикийн хэлтсийн дарга
	Б.Хэрлэнчимэг	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга
	С.Эрдэнэжаргал	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
	Ж.Энх-Амгалан	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
	О.Цэндгомбо	Онон, балжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны газрын дарга

237011999

М.Шүрэнцэцэг	Хэрлэн сумын Засаг дарга
Д.Баянмөнх	Баян-Овоо сумын Засаг дарга
О.Лхагвадорж	Баян-Адрага сумын Засаг дарга нар
А.Мөнхбайгаль	Норовлин сумын Засаг дарга
Б.Нандинцэцэг	Хэрлэн голын сав газрын дарга
Т.Алтанчимэг	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг хөгжлийн бодлого хариуцсан ажилтан
Ж.Цэнджав	Аймгийн жендерийн салбар хорооны гишүүн
Б.Цэрэнчимэд	Аймгийн ХАА-ын хоршоологчдын холбооны тэргүүн
Д.Батболд	Онон мөрний нөхөрлөлүүдийн холбооны дарга
З.Ууганбаяр	Аймгийн байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн нэгдсэн холбооны дарга

2. Газар зохион байгуулалтын багц төлөвлөгөө боловсруулах Ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг боловсруулж, шаардлагатай зардлыг 2022 оны орон нутгийн төсөвт суулгахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Д.Баярхүү)-д үүрэг болгосугай.

3. Тендерийг зарлуулах бэлтгэл хангах, шалгарсан ажил гүйцэтгэгчтэй хамтран ажиллаж, ажлын гүйцэтгэл, чанарт хяналт тавьж, шаардлагатай мэдээллээр тухай бүрт хангах, санал, дүгнэлт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг ажлын хэсэг (Э.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

4. Ажлын хэсэг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон Баян-Адарга, Баян-Овоо, Норовлин сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар тус тус хэлэлцүүлж, холбогдох саналыг тусган төлөвлөгөөнүүдийн төслийн эцсийн хувилбарыг 2022 оны 10 дугаар сард багтаан дуусгаж аймгийн Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ

